



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/283

Арвайхээр

**Эрх шилжүүлэх тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Төсөвт өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоолын 1.8-т батлагдсан Төрийн албан хаагчдын сургалтын төвийн өргөтгөлийн зардал 50,000,000 (тавин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Цагдаагийн газар (О.Ганбат)-д, 1.11-т батлагдсан Зүүнбаян-Улаан сумын гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх зардал 30,000,000 (гучин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Зүүнбаян-Улаан сумын Засаг дарга (Б.Ууганбаяр)-д, 1.12-т батлагдсан Гучин-Ус сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын зардал 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг зарцуулах эрхийг Гучин-Ус сумын Засаг дарга (Р.Намгилрагчаа)-д, 1.13-т батлагдсан Бүрд сумын Бизнес хөгжлийн төвийн засварын зардал 40,000,000 (дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Бүрд сумын Засаг дарга (Г.Баярмөнх)-д тус тус шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, тендерийн бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг Цагдаагийн газар, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100627